# ХЭРХЭН БҮРТГҮҮЛЭХ ВЭ?

**Алхам 1.** Хэрэглэгчийн бүртгэл үүсгэх буюу Кампуст бүртгүүлэх

1. Сайтын баруун дээд буланд байрлах **'Нэвтрэх'** холбоос дээр дар.




Эсвэл http://www.mongolcampus.org/login/index.php хаягаар орно уу.

2. Баруун талд байрлах **'Шинээр хэрэглэгчийн эрх үүсгэх'** товчлуур дээр дар.



3. Бүх талбарыг бөглөөд **'Шинээр хэрэглэгчийн эрх үүсгэх'** товчлуур дээр дарна.



Нэвтрэх шинэ хэрэглэгч нэр, нууц үг үүсгэх

Хэрэглэгчийн нэр*

Нууц үг*

Ил харуулах

Өөрийнхөө тухай мэдээлэл өгнө үү

И-мэйл хаяг*

И-мэйл (дахиад)*

Нэр*

Овог нэр*

Хот/дүүрэг*

Улс*

Улс сонгох

Шинээр хэрэглэгчийн эрх үүсгэх

Болих

* тэмдэгтэй талбарыг заавал бөглөх шаардлагатай.

**Анхаарах зүйлс:** Таны бүртгэлд ашигласан нэрүүд сургалтын явцад таныг төлөөлөхөөс гадна, сургалтыг амжилттай дуусгасны дараа таны сертификатанд бичигдэх юм. Та бүртгэлийн талбарыг бөглөхдөө дараах дүрмийг баримтална уу.

— Талбарыг бөглөхдөө Unicode ашиглах. Ингэснээр таны мэдээлэл бусад суралцагчид болон багш нарт тэмдэгтийн эвдрэлгүйгээр уншигдах юм.

— Том, жижиг үсэг ашиглах боломжтой.

— Таны нэр бүхэлдээ (Овог + Нэр) 40 тэмдэгтээс хэтрэхгүй байх.

Жишээ: Хэрэв та бүртгэлийн мэдээллээ:

Овог: **Баярсайхан**, Нэр: **Нарангарав** гэсэн бол таны сертификат дээрх таны нэр **Баярсайхан Нарангарав** гэж хэвлэгдэх болно.

Хэрэв таны нэр бүртгүүлэхэд **40** тэмдэгтээс хэтэрч байвал таны нэрийг эхний 40 тэмдэгтээр таслан авах болно.

4. Танд системээс и-мэйл очно. И-мэйл доторх холбоос дээр дарснаар таны бүртгэл идэвхижнэ. Хэрэв танд и-мэйл очихгүй бол **'Spam'** эсвэл **'Junk mail'** фолдероо шалгаарай.

**Алхам 2.** Сонгосон онлайн курст бүртгүүлэх




1. **Бүртгэлийн хуудас бөглөх**: Та Цахим Мэдлэг Кампуст бүртгүүлсний дараа өөрийн оролцохыг хүсч байгаа онлайн курсын товч тайлбарын доор байрлах бүртгүүлэх холбоос дээр дарж гарч ирэх анкетыг бөглөнө. (эсвэл http://www.mongolcampus.org/mod/resource/view.php?id=70 холбоосоор орж бүртгэлийн хуудсыг бөглөнө үү.) Бүртгэлийн хуудсыг талбар бүрийн ард байрлах шаардлагын дагуу үнэн, зөв бөглөнө. Учир нь энд бичсэн таны мэдээлэл сургалтыг амжилттай дуусгасны дараа манай төгсөгчдийн мэдээллийн санд хадгалагдан үлдэж, таны сертификат дээрх бичигдэх юм.

2. **Төлбөр төлөх:** Та Курсын төлбөр 95,000 төгрөгийг Цахим Мэдлэг кампусын Голомт банкин дахь төгрөгийн 110 293 6629, валютын 110 293 6630 дансаар шилжүүлэх буюу эсвэл МТҮП-ийн байрны 113 тоотод ирж бэлнээр төлж болно.

3. Та дээрх 2 үйлдлийг гүйцэд хийсэн бол таныг курст бүртгэж авсан тухай и-мэйл таны бүртгүүлсэн и-мэйл хаягаар очно. Хэрэв танд бүртгэлтэй холбоотой и-мэйл очихгүй бол **'Spam'** эсвэл **'Junk mail'** фолдероо шалгаарай.